



Сурагчид болон тэдгээрийн гэх бүлийнхэнтэй байгуулах цахим төхөөрөмжийн ашиглалт болон хариуцлагын гэрээ

Арлингтоны Төрийн Өмчит Сургуулиуд нь цэцэрлэгийн өмнөх наснаас 12-р анги хүртэлх суралцагчдынхаа **өдөр тутмын суралцах үйл ажиллагааг** дэмжихийн тулд төхөөрөмж хуваарилан өгдөг билээ. Өгсөн төхөөрөмжийг ашиглах эсвэл АТӨС-ийн сүлжээнд нэвтрэхдээ Сургуулийн [Удирдах Зөвлөлийн I-9.2.5.1 Цахим Төхөөрөмжийг Ашиглах Журам \(AUP\) болон Дижитал Төхөөрөмжийн зааварчилгааг](#) дагаж мөрдөх ёстой бөгөөд үүнийг АТӨС-н Сурагчийн ёс зүйн дүрмээс харж болно. Эдгээр журам, зааварчилгааг уншиж танилцаад төхөөрөмжийг ашиглахдаа хэрхэн хариуцлагатай хандах талаар гэр бүлийнхэнтэйгээ ярилцахыг бид та бүхэнд зөвлөж байна.

Доор Цахим Төхөөрөмжийг Ашиглах Журам болон АТӨС-иудын гарын авлага дахь зарим чухал санах ёстой зүйлсийг энд оруулав. Дэлгэрэнгүй мэдээллийг http://www.apsva.us/digital_learning хаягаас авах боломжтой. Таны ашиглах төхөөрөмж бол АТӨС-иудын хууль ёсны өмч юм.

- Төхөөрөмж болон АТӨС-иудын сүлжээг ашиглахдаа Арлингтоны Төрийн Өмчит Сургуулиудын дүрмийг дагаж мөрдөх.
- Төхөөрөмж болон АТӨС-иудын сүлжээг ашиглахын өмнө сургуулийн журам болон ажилтнуудын зааварчилгааг дагаж мөрдөх.
- Зохимжтой бус агуулга гарч ирвэл багш болон администраторт даруй мэдэгдэх.
- Аюулгүй байдлын болон техник хангамжийн асуудлуудыг багшид болон администраторт мэдэгдэх.
- Зохиогчийн эрх болон шударга хэрэглээний хуулийг дагаж мөрдөх.
- Зөвхөн зөвшөөрөл авах эсвэл мэдэгдсэний үндсэн дээр бусдын дууг хураах, дүрсийг бичих эсвэл зураг авах.
- Зөвхөн өөрт ноогдсон төхөөрөмж болон дагалдах хэрэгслийг ашиглах.
- Төхөөрөмж дээр iCloud данс нээхгүй байх.
- Зөвхөн АТӨС-иудын каталогит нэрлэгдсэн, уг сургуулиудаас баталгаажуулсан аппликэйшнүүдийг ашиглах.

Төхөөрөмжийг хадгалах журам:

- Төхөөрөмж болон дагалдах хэрэгслийг өөрт харагдах, хялбархан олох газарт хадгалах.
- Уутыг нь төхөөрөмж дээрээ байрлуулах.
- Төхөөрөмжийг цэвэрхэн байлгах бөгөөд элдэв стикер наах, дээр нь зурахгүй байх.
- Хоол хүнс болон уух зүйлээ төхөөрөмжөөс хол байлгах.
- Төхөөрөмжийг машиндаа удаан хадгалахаас зайлсхийх бөгөөд хүний нүдэнд өртөхөөр газар байлгахгүй байх.

Төхөөрөмжөө гэртээ ашиглахдаа гэр бүлийнхээ төхөөрөмжийн ашиглалтын дүрмийг дагаж мөрдөж байгаа эсэхээ шалгаарай. Хэрвээ төхөөрөмж болон түүний дагалдах хэрэгсэл нь санаатай (зориудаар) эсвэл хайхрамжгүй (боломжгүй) үйлдлээс болж эвдэрсэн, гэмтсэн, алдагдсан бол танай гэр бүл санхүүгийн хариуцлага хүлээх болно. Эвдрэл, алдагдлын хураамжийг АТӨС-иудын вэб сайтын [Төхөөрөмжид гэмтэл учруулах](#) хуудаснаас олж болно.



Сурагчид болон тэдгээрийн гэх бүлийнхэнтэй байгуулах цахим төхөөрөмжийн ашиглалт болон хариуцлагын гэрээ

Миний бие дээрх мэдэгдлүүдийг уншиж танилцсан эсвэл надад тайлбарласан бөгөөд АТӨС-иудын Сурагчийн ёс зүйн дүрэм дэх АТӨС, АUP болон дижитал төхөөрөмжийн зааварчилгааг дагаж мөрдөхийг зөвшөөрч байна.

_____ сурагчийн нэр

_____ сурагчийн ID

_____ Огноо

Миний бие дээрх мэдэгдлийг уншиж, ойлгосон бөгөөд нэмэлт мэдээллийг АТӨС-иудын вэб сайт болон хүүхдийнхээ сургуулиас авах боломжтой гэдгийг мэдэж байгаа болно.

_____ Эцэг эх/Хууль ёсны асран
хамгаалагчийн гарын үсэг _____ Огноо